**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2018 оны 08 сарын 01 өдөр Дугаар А/316 Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дах хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан ''Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам''-ын 2.7, 2.9 дэх заалт, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 09 дүгээр тэмдэглэл, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох 6 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

081307

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 01-ны өдрийн
А/316 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харъяалал | Ажиллах байгууллага | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөрлийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Баэ Кэун Вүүк<br>Bae Keunwook | Бүгд Найрамдах Солонгос Улс | Сонгинохайрхан дүүргийн “Цэцэг Хайрхан” өрхийн эрүүл мэндийн төв | ГЭ0002079 | Хүүхэд судлал | Эмчлэх | 2018.08.04-2018.08.09 /6 хоног/ |
| 2. | Юү Хе Син<br>Yu Hye Sin | Бүгд Найрамдах Солонгос Улс | Сонгинохайрхан дүүргийн “Цэцэг Хайрхан” өрхийн эрүүл мэндийн төв | ГЭ0002080 | Дотрын анагаах судлал | Эмчлэх | 2018.08.04-2018.08.09 /6 хоног/ |
| 3. | Вон Жонг Мэн<br>Won Jong Man | Бүгд Найрамдах Солонгос Улс | Сонгинохайрхан дүүргийн “Цэцэг Хайрхан” өрхийн эрүүл мэндийн төв | ГЭ0002081 | Уламжлалт анагаах судлал | Эмчлэх | 2018.08.04-2018.08.09 /6 хоног/ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Лии Гиро<br><br>Lee Giro | Бүгд Найрамдах Солонгос Улс | Сонгинохайрхан дүүргийн “Цэцэг Хайрхан” өрхийн эрүүл мэндийн төв | ГЭ0002082 | Өрхийн анагаах судлал | Эмчлэх | 2018.08.04-2018.08.09 /6 хоног/ |
| 5. | Чо Сун Гю<br><br>Cho Sungkyu | Бүгд Найрамдах Солонгос Улс | Улсын гуравдугаар төв эмнэлэг | ГЭ0002083 | Зүрх, судасны мэс засал судлал | Эмчлэх | 2018.09.01-2018.09.08 /8 хоног/ |
| 6. | Ким Сү Жин<br><br>Kim Su Jin | Бүгд Найрамдах Солонгос Улс | Улсын гуравдугаар төв эмнэлэг | ГЭ0002084 | Хүүхдийн зүрх судлал | Эмчлэх | 2018.09.01-2018.09.08 /8 хоног/ |

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 01-ны өдрийн
А/316 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харъяалал | Ажиллах байгууллага | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөр лийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Жон Бён Жү<br>Song Keum Young | Бүгд Найрамдах Солонгос Улс | “ДУБ” ХХК-ийн “Мед траума хоспитал” эмнэлэг | ГЭ0002085 | Мэдрэлийн мэс засал судлал | Эмчлэх | 1 жил |